

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/208/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
Сүхбаатар сум 2026 он	Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn
	Аудитор: Ц.Уртнасан Утас: 7036-2442 Цахим хаяг: urtaa6969@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сурбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАЯНГОЛ
СУМЫН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ц.ОРХОНЦЭЦЭГ ТАНАА

2026.02.25 № СЭН-2026/002/НН-СТН-ТМЗ
танай -ны № -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Баянгол сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Боловсролын яамнаас 2,066.4 мянган төгрөгийн зөөврийн компьютер, Хүлэг морин спорт уяачдын холбооноос 29,000.0 мянган төгрөгийн Портер-2 ачааны автомашин, эцэг эх асран хамгаалагчдаас 4,169.0 мянган төгрөгийн 4 ширхэг телевизор зэргийг үнэ төлбөргүй хүлэн авч бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлог тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын 1 дүгээр цэцэрлэг нь тайлант онд 5 зорилт, 29 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээгээр 94.8 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

№	Данс-ны код	Дансны нэр, төрөл	1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1	1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	255,474,618.53	147,272,876.96
2	31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	138,326,037.51	19,908,645.94
3	31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.0	
4	31110	Төгрөг	0.0	
5	31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	138,326,037.51	19,908,645.94
6	31210	Төгрөг	138,326,037.51	0
7	31211	Төрийн сангийн харилцах	138,326,037.51	19,908,645.94
8	35	БАРАА МАТЕРИАЛ	117,148,581.02	127,364,231.02
9	35100	Түүхий эд материал	1,284,000	1,284,000
10	35130	Эм боох материал	1,284,000	1,284,000
11	35400	Хангамжийн материал	115,864,581.02	126,080,231.02
12	35410	Бичиг хэргийн материал	2,678,500	2,219,050
13	35460	Хүнсний материал	796,904	465,004
14	35470	Бусад хангамжийн материал	112,389,177.02	123,396,177.02
15	2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	920,189,325.92	846,645,199.63
16	39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	920,189,325.92	846,645,199.63
17	39200	Биет хөрөнгө	904,900,996.97	831,606,870.84
18	39201	Барилга, байгууламж, орон сууц	857,377,385	857,377,385
19	39202	Хуримтлагдсан элэгдэл	-132,627,526.71	-153,422,178.03
20	39203	Авто-тээврийн хэрэгсэл	0.0	29,000,000
21	39204	Хуримтлагдсан элэгдэл	0.0	-483,333.33
22	39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	103,023,828.64	91,291,263.64
23	39206	Хуримтлагдсан элэгдэл	-12,422,860.25	-51,883,136.74
24	39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	73,601,131.5	69,251,171.5
25	39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,764,592.64	-37,018,733.21
26	39214	Бусад үндсэн хөрөнгө	36,378,801.4	39,457,741.4
27	39215	Хуримтлагдсан элэгдэл	-9,325,955.97	-14,624,095.39
28	39217	Ном	2,660,786	2,660,786

29	39300	Биет бус хөрөнгө	15,288,328.95	15,038,328.79
30	39301	Програм хангамж	1,250,000	1,250,000
31	39302	Хуримтлагдсан элэгдэл	-937,499.85	-1,187,500.01
32	39303	Бусад биет бус хөрөнгө	14,975,828.8	14,975,828.8
33	3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	1,175,663,944.45	993,918,076.59
34	5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,175,663,944.45	993,918,076.59
35	51	Засгийн газрын хувь оролцоо	1,175,663,944.45	993,918,076.59
36	51100	Засгийн газрын оруулсан капитал	497,363,823	497,363,823
37	511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	497,363,823	497,363,823
38	51200	Хуримтлагдсан үр дүн	584,060,944.13	402,315,076.27
39	51210	Өмнөх үеийн үр дүн	417,500,251.39	584,060,944.13
40	51220	Тайлант үеийн үр дүн	166,560,692.74	-181,745,867.86
41	51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	94,239,177.32	94,239,177.32
42	6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	1,175,663,944.45	993,918,076.59

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

№	Данс-ны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
1	I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,395,992,058.72	1,384,957,300
2	12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	153,236,458.72	1,384,957,300
3	120	Нийтлэг татварын бус орлого	153,236,458.72	68,296,900
4	120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.0	35,000
5	1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	35,000
6	120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	127,105,960.4	35,235,400
7	120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	26,130,498.32	33,026,500
8	122	Тусламжийн орлого	0.0	1,316,660,400
9	1221	Хандив тусламж /дотоод/	0.0	1,316,660,400
10	12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	0.0	1,316,660,400
11	122111	Урсгал санхүүжилтийн орлого\	0.0	0.0
12	13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,242,755,600	1,316,660,400
13	1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,242,755,600	1,316,660,400

14	131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,242,755,600	1,316,660,400
15	II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,229,431,365.98	1,542,187,667.86
16	21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,229,431,365.98	1,542,187,667.86
17	210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,219,807,165.98	1,542,187,667.86
18	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	899,200,192.61	1,142,380,183.58
19	210101	Үндсэн цалин	535,263,391.01	660,976,295.43
20	210102	Нэмэгдэл	321,980,541.54	413,080,369.55
21	210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.0	31,000,000
22	210104	Урамшуулал	41,956,260.06	37,323,518.6
23	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	112,498,897.76	141,113,556.16
24	210201	Тэтгэврийн даатгалын зардал	77,341,802	95,747,851.96
25	210202	Тэтгэмжийн даатгалын зардал	9,099,035.52	11,392,553.24
26	210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	4,503,317.83	5,692,216.61
27	210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	4,312,948.5	5,656,106.85
28	210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	17,241,793.91	22,624,827.5
29	2104	Хангамж, бараа материалын зардал	35,000	0.0
30	210401	Бичиг хэрэг	35,000	0.0
31	2105	Нормативт зардал	124,255,765	113,349,916
32	210502	Хоол, хүнс	124,255,765	113,349,916
33	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,558,400	3,627,257.83
34	210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,558,400	3,627,257.83
35	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	80,258,910.61	141,716,754.29
36	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,106,203	18,698,944.52
37	210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,096,250	10,530,750
38	210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	52,056,457.61	112,487,059.77
39	213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,624,200	0
40	2132	Бусад урсгал шилжүүлэг	9,624,200	0.0
41	213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,624,200	0.0
42	III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	166,560,692.74	-157,230,367.86
43	V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.0	24,515,500
44	225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	0.0	24,515,500
45	VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	0.0	-24,515,500
46	VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	166,560,692.74	-181,745,867.86

02.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	Данс-ны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,242,755,600	1,316,660,400
2	12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.0	1,316,660,400
3	122	Тусламжийн орлого	0.0	1,316,660,400
4	1221	Хандив тусламж /дотоод/	0.0	1,316,660,400
5	12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	0.0	1,316,660,400
6	122111	Урсгал санхүүжилтийн орлого\	0.0	1,316,660,400
7	13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,242,755,600	0.0
8	1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,242,755,600	0.0
9	131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,242,755,600	0.0
10	II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,182,843,668.37	1,435,077,791.57
11	21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,182,843,668.37	1,435,077,791.57
12	210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,173,219,468.37	1,435,077,791.57
13	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	899,200,192.61	1,142,380,183.58
14	210101	Үндсэн цалин	535,263,391.01	660,976,295.43
15	210102	Нэмэгдэл	321,980,541.54	413,080,369.55
16	210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.0	31,000,000
17	210104	Урамшуулал	41,956,260.06	37,323,518.6
18	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	112,498,897.76	141,113,556.16
19	210201	Тэтгэврийн даатгалын зардал	77,341,802	95,747,851.96
20	210202	Тэтгэмжийн даатгалын зардал	9,099,035.52	11,392,553.24
21	210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	4,503,317.83	5,692,216.61
22	210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	4,312,948.5	5,656,106.85
23	210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	17,241,793.91	22,624,827.5
24	2105	Нормативт зардал	124,138,175	113,018,016
25	210502	Хоол, хүнс	124,138,175	113,018,016
26	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,558,400	5,886,257.83
27	210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,558,400	5,886,257.83
28	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,823,803	32,679,778
29	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,741,303	22,608,478
30	210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,082,500	10,071,300
31	213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,624,200	0.0

32	2132	Бусад урсгал шилжүүлэг	9,624,200	0.0
33	213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,624,200	0.0
34	III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	59,911,931.63	-118,417,391.57
35	V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	5,562,300	0
36	22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,562,300	0
37	2200	Дотоод эх үүсвэрээр	5,562,300	0
38	225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,562,300	0.0
39	VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-5,562,300	0
40	VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	54,349,631.63	-118,417,391.57
41	101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	83,976,405.88	138,326,037.51
42	20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	138,326,037.51	19,908,645.94

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Данс-ны код	Дансны нэр, төрөл	/төгрөгөөр/			
			Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	497,363,823	94,239,177.32	417,500,251.39	1,009,103,251.71
2	3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	497,363,823	94,239,177.32	417,500,251.39	1,009,103,251.71
3	9	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	166,560,692.74	166,560,692.74
4	10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	497,363,823	94,239,177.32	584,060,944.13	1,175,663,944.45
5	11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	497,363,823	94,239,177.32	584,060,944.13	1,175,663,944.45
6	13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	497,363,823	94,239,177.32	584,060,944.13	1,175,663,944.45
7	19	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	-181,745,867.86	-181,745,867.86
8	20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	497,363,823	94,239,177.32	402,315,076.27	993,918,076.59

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

№	Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,317,888,100	1,316,660,400	1,227,700.0	99.9
2	12	Татварын бус орлого	1,317,888,100	1,316,660,400	1,227,700.0	99.9
3	122	Тусламжийн орлого	1,317,888,100	1,316,660,400	1,227,700.0	99.9
4	122005	Төсвөөс санхүүжих	1,317,888,100	1,316,660,400	1,227,700.0	99.9
5	II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,448,547,000	1,435,077,791.57	13,469,208.4	99.0
6	21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,448,547,000	1,435,077,791.57	13,469,208.4	99.0
7	210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,448,547,000	1,435,077,791.57	13,469,208.4	99.0
8	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,147,392,900	1,142,380,183.58	5,012,716.4	99.5
9	210101	Үндсэн цалин	723,822,400	660,976,295.43	62,846,104.6	91.3
10	210102	Нэмэгдэл	394,640,300	413,080,369.55	- 18,440,069.6	104
11	210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.0	31,000,000	- 31,000,000.0	
12	210104	Урамшуулал	28,930,200	37,323,518.6	- 8,393,318.6	129
13	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл	142,656,900	141,113,556.16	1,543,343.8	98.9
14	210201	Тэтгэврийн даатгал	96,761,200	95,747,851.96	1,013,348.0	98.9
15	210202	Тэтгэмжийн даатгал	11,473,900	11,392,553.24	81,346.8	99.2
16	210203	ҮОМШӨ-ний даатгал	5,737,000	5,692,216.61	44,783.4	99.2
17	210204	Ажилгүйдлийн даатгал	5,737,000	5,656,106.85	80,893.2	98.5
18	210205	Эрүүл мэндийн даатгал	22,947,800	22,624,827.5	322,972.5	98.5
19	2105	Нормативт зардал	119,875,200	113,018,016	6,857,184.0	94.2
20	210502	Хоол, хүнс	119,875,200	113,018,016	6,857,184.0	94.2
21	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,886,300	5,886,257.83	42.2	100
22	210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,886,300	5,886,257.83	42.2	100
23	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,735,700	32,679,778	55,922.0	99.8

24	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,664,400	22,608,478	55,922.0	99.7
25	210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,071,300	10,071,300	-	100
26	8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-130,658,900	-118,417,391.57	- 12,241,508.4	90.6
27	9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	130,658,900	118,417,391.57	12,241,508.4	90.6
28	7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	130,658,900	118,417,391.57	12,241,508.4	90.6
29	4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	138,326,037.51	- 138,326,037.5	
30	5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	19,908,645.94	- 19,908,645.9	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

№	Дан-ны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	84,673,100	74,561,713.89	10,111,386.11	88.0
2	12	Татварын бус орлого	84,673,100	74,561,713.89	10,111,386.11	88.0
3	122	Тусламжийн орлого	84,673,100	74,561,713.89	10,111,386.11	88.0
4	122005	Төсвөөс санхүүжих	84,673,100	74,561,713.89	10,111,386.11	88.0
5	II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	84,673,100	74,561,713.89	10,111,386.11	88.0
6	21	УРСГАЛ ЗАРДАЛ	84,673,100	74,561,713.89	10,111,386.11	88.0
7	210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	84,673,100	74,561,713.89	10,111,386.11	88.0
8	2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,859,100	64,747,713.89	10,111,386.11	86.4
9	210301	Гэрэл, цахилгаан	23,400,000	13,658,518.94	9,741,481.06	58.3

10	210302	Түлш, халаалт	50,365,700	50,365,834.95	- 134.9	100.0
11	210303	Цэвэр, бохир ус	1,093,400	723,360	370,040.00	66.1
12	2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,814,000	9,814,000	-	100.0
13	210604	Урсгал засвар	9,814,000	9,814,000	-	100.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой **41,452.4** мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайланд тусгагдсан бараа материалын эхний үлдэгдэл нь материалын тайлангийн эхний үлдэгдлээс 14,100.0 мянган төгрөгөөр илүү тайлагнагдсан.
- Санхүүгийн байдлын тайланд тусгагдсан үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл нь үндсэн хөрөнгийн тайлангийн элэгдлийн эхний үлдэгдлээс 27,352.4 мянган төгрөгөөр илүү тайлагнагдсан.

Дээрх алдаанууд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалт болон УСНББОУС-12 “*Бараа материал*”-ийн 16¹, УСНББОУС-17 “*Үндсэн хөрөнгө*”-ийн 13², Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “*Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам*”-ын 3.4, 10.23, 10.26 дахь заалтууд болон “*Үнэлгээ ба хуваарилалт*” батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

Аудитаар нийт 46,641.5 мянган төгрөгийн зөрчил³ илэрснээс 2,667.7 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 43,973.8 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгөв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **2,667.7** мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 12,294.3 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

Commented [OA1]: Дүгнэлтийн үндэслэлийг тайлбарлах

3.2 Албан шаардлага

3.2.1. Тус цэцэрлэгийн хоол зүйц Б.Болормаад батлагдаагүй орон тоо болох архив, бичиг хэргийн ажилтныг хавсран ажилласны 20 хувийн нэмэгдэлд 497.7 мянган төгрөгийн цалин олгосон байна.

¹ Бараа материалыг арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн тохиолдолд тэдгээрийн ертгийг тухайн олж эзэмшсэн өдрөөрх бодит үнэ цэнээр хэмжинэ.

² Элэгдэл гэдэг нь хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацааны туршид хуваарилах системтэй хуваарилалт юм, ашиглалтын хугацаа гэдэг нь а)байгууллагад уг хөрөнгө ашиглагдах боломжтой байхаар хүлээгдэж буй хугацаа,

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалт болон эрхлэгчийн “Бүтэц орон тоо” баталсан 2025 оны 1-р сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсөв, орон тоог мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

3.2.2 Мэдээлэл технологийн үйлчилгээ зардлаас 2,170.0 мянган төгрөгийг хичээл, сургалтын үйл ажиллагааны зардалд бүлэг хооронд зориулалт бусаар гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нормативт зардалтай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Хүүхдийн хоолны хүнсний материалыг олгохдоо насны ялгавартай нормативын дагуу тооцож олгоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2020 оны 12 сарын 2 өдрийн А/166 / А/559/ 222 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Цэцэрлэгийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах Хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ”-г тогтоосон тушаалыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хүүхдийн хоолны хүнсний материалыг батлагдсан нормативын дагуу насны ялгавартайгаар тооцож олгох зөвлөмж хүргүүлээ.

2. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:

2.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй тайлант оны эцэст ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа нийт 43,973.8 мянган төгрөгийн анхны үнэтэй 61 нэр төрлийн

хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т ирүүлж шийдвэрлүүлнэ”, УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 13 (б)-д “Нэгээс дээш жил тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм” ХЗУ4-д “... байгууллага нь тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр түүний одоогийн бодит үнэ цэнээр дахин үнэлэх хэрэгтэй...” гэсэн заалтууд болон болон “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох, актлах саналыг бэлтгэн, холбогдох газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5⁴ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

⁴ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
БМ-ын тайлангийн эхний үлдэгдэл санхүүгийн байдлын тайлангийн БМ-ын эхний үлдэгдлээс зөрүүтэй илэрхийлэгдсэн,	1	14,100.0			1	14,100.0	1	14,100.0				
Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэлийн эхний үлдэгдэл санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлээс зөрүүтэй илэрхийлэгдсэн	1	27,352.4			1	27,352.4	1	27,352.4				
Дүн	2	41,452.4			2	41,452.4	2	41,452.4				

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн

